

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	Нэр Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Овог: Орлой Эцгийн нэр: Хүрэлбаатар Нэр: Мөнхзул
2	Хүсэлт гаргагчийн хаяг Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	Хаяг: Улаанбаатар хот
3	Төрсөн огноо Төрсөн газар	Төрсөн он: Төрсөн газар:
4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	<ul style="list-style-type: none"> - Удирдлагын академи, удирдахуйн ухааны сургууль, “төрийн удирдлагын магистр”, 2016-2017 он - Удирдлагын академи, төрийн алба, удирдлагын сургууль, “төрийн захиргааны менежмент”, 2015-2016 он - Хүмүүнлэгийн ухааны их сургууль, хүмүүнлэгийн ухааны бакалавр, “англи хэлний орчуулагч”, 2004-2007 он - Монгол улсын их сургуулийн Хууль зүйн дээд сургууль, “эрх зүйч”, бакалавр, 1993-1997он
5	Ажил эрхлэлт Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	<p>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын гэрээ эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах референт, 2015-2020 он - Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, 2013-2015 он - Сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга, ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, 2011-2013 он - Бодлого дүн шинжилгээ хариуцсан референт 2009-2011 он <p>Хаяг: Чингэлтэй дүүргийн Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын 11 байр, 501 тоот Утас:260284,320284 Цахим хуудас: http://nhrcm.gov.mn/</p> <p>Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв 2002-2009 он “эрх зүйн шинэчлэл хөтөлбөрийн зохицуулагч” 1998-2002 он “хуулийн зөвлөх”</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, 6 хороо, 40 байр, 03,06 тоот Утас: 976-70119949</p>

		<p>Цахим хуудас: http://www.safefuture.mn/</p> <p>Сонгино Хайрхан дүүргийн шүүх 1997-1998 он “нарийн бичгийн дарга”</p> <p>Хаяг: Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг 17 хороо, Утас:976-70007081 Цахим хуудас: http://songinokhairkhan.civilcourt.gov.mn/</p>
6	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.</p>	<p>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвшиж байна.</p>
7	<p>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил Хүсэлт гарагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. 	<p>Эрх зүйч мэргэжлээр ажилласан нийт хугацаа : 22 жил 10 сар :</p> <p><u>Хүний эрхийн Үндэсний Комисст</u> Ажилласан нийт жил: 10 жил 10 сар</p> <p>2015-2020 Олон улсын гэрээ эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах референт 2013-2015 Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга 2011-2013 Сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга 2009-2011 Бодлого, дүн шинжилгээ хариуцсан референтээр тус тус эрх зүйч мэргэжлээр ажилласан.</p> <p><u>Эрх зүйн чиглэлээрх ажлын байрны тодорхойлолт:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хүний эрхийн олон талт гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах боломжийг судлан шинжилж санал боловсруулах, нөлөөллийн ажлыг хариуцан зохион байгуулах; - Комиссоос НҮБ-ын хүний эрхийн олон улсын механизмд явуулах хөндлөнгийн мэдээлэл, илтгэлийн төслийг боловсруулах; - Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж гаргах; - Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийн талаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулж, дүн шинжилгээ хийх; - Хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх; - НҮБ-ын хүний эрхийн гэрээ, конвенцод нийцүүлэн үндэсний хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсронгуй болгох, НҮБ-ын гэрээний хороонд гомдол, мэдээлэл гаргах үндэсний чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах; <p><u>Комиссын жөндөр, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг хариуцан мэргэшин ажилладаг бөгөөд хариуцсан эрхийн чиглэлээр:</u></p> <ul style="list-style-type: none"> - иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх; - гомдлын дагуу хяналт шалгалтад оролцох; - хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн зөрчлийг арилгуулахаар

		<p>гаргасан Комиссын гишүүний зөвлөмж, шаардлагын төслийг боловсруулах;</p> <ul style="list-style-type: none"> - НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг, Монгол Улсын Засгийн газрын илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын гэрээний хороодоос гаргасан зөвлөмж, НҮБ-ын тусгай илтгэгчдийн зөвлөмжийг хэрэгжилтэд хариуцсан эрхийн хүрээнд хяналт тавих; - хариуцсан эрхийн хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулах гэх мэт. <p>Хүчирхийллийн эсрэг Үндэсний Төвд Ажилласан нийт жил: 12 жил</p> <p>2002-2009 он Эрх зүйн шинэчлэл хөтөлбөрийн зохицуулагч 2002-1997 он Хуулийн зөвлөх</p> <p>Ажлын байрны тодорхойлолт:</p> <ul style="list-style-type: none"> - гэр бүлийн болон хүчингийн гэмт хэргийн хохирогчдод хууль эрх зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэх; - хүүхэд, гэр бүл, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд судалгаа, шинжилгээ, анализ хийх; - эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийн асуудлаарх хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хуулийн төсөл боловсруулах, хуульд санал өгөх;
8	<p>Ёс зүй Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> -сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх; -сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх. 	<ul style="list-style-type: none"> - Сахилгын шийтгэл авч ажлаас халагдаж байгаагүй - Улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй болно.
9	<p>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний 	<p>1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлыг 2 жил тутам УИХ-д тайлагнах үүргийг Комисст олгосон. Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх ажилд Комиссын жендэрийн асуудлыг хариуцан ажиллагдийн хувьд манлайлан оролцож, хуулийн хэрэгжилтийн асуудлаар нийт 4 удаагийн дүн шинжилгээ хийж, Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11, 13, 16, 18 дахь илтгэлүүдэд тусгаж, УИХ-д тайлагнасан. Энэ ажлуудын хүрээнд дүн шинжилгээний удирдамж, асуулга боловсруулах, мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах ажлыг ахлан хариуцаж ирсэн. Комиссын тогтмол дүн шинжилгээний үр дүнд уг хуулийн хэрэгжилт сайжирсан. Тухайлбал 2018 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар үүрэг хүлээсэн төрийн нийт 60 гаруй байгууллагуудыг хамруулан дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр нийт 4 зөвлөмжийг дэвшүүлсэн нь биелсэн үзүүлэлттэй байна. (ХЭҮК, 2018 он) http://nhrcm.gov.mn/мэдээ/илтгэл/</p>

<p>нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	<p>2. Комиссоос НҮБ-ын хүний эрхийн механизмд хөндлөнгийн мэдээлэл, илтгэл хүргүүлэх үйл ажиллагаанд өөрийн хариуцсан эрхийн хүрээнд тогтмол оролцож ирсэн. Хамгийн сүүлийн байдлаар авч үзэхэд 2018 онд ИБУТЭТК-ын хэрэгжилтэд хяналт тавьдаг Хүний эрхийн хороонд уг конвенцын хэрэгжилтийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүн, ахиц дэвшил, хүндрэл бэрхшээлийн талаар, Хүний эрхийн байгууллагуудын дэлхийн холбоонд эмэгтэйчүүд, охидын эсрэг үйлдэгдэж буй бүх төрлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ХЭҮК-оос авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг бэлтгэн тус тус хүргүүлсэн. (ХЭҮК, 2018 он)</p> <p>3. Монгол улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл ажиллагаанд 2003 оноос хойш идэвхтэй оролцож, энэ хүрээнд дараах гол ажлуудыг хийж гүйцэтгэж ирсэн. Үүнд:</p> <p><u>УИХ-аас 2005 онд баталсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулах хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн дэргэд байгуулагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулах “лобби” төслийн зохицуулагчаар ажиллаж, Монгол Улсын анхны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг боловсруулахад гар бие оролцож ирсэн. (батламжийг хавсаргав. Хавсралт 1) - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг батлуулах нөлөөллийн ажлыг зохион байгуулахад оролцож, хуулийг батлуулахад нөлөөлөх ТББ-ын дэргэдэх ажлын хэсгийн өдөр тутмын ажлыг зохион байгуулж ажилласан. - Хуулийг батлуулахтай холбогдон хийсэн судалгааны багт ажиллаж, уг судалгаануудыг нэгтгэн шийдвэр гаргагч нарт зориулсан “Гэр бүлийн хүчирхийлэл” баримтат цомгийг эмхтгэн гаргасан. (ХЭҮТ 2004 он) <p><u>УИХ-аас 2016 онд баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн хүчирхийллийн эрх зүйн орчин, хүчирхийллээс үүдэлтэй эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийн тулгамдсан асуудлуудыг судалж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа талаарх санал, зөвлөмжийг дэвшүүлж, Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлд тусган УИХ д тайлагнасан. (ХЭҮК, 2014 он.) http://nhrcm.gov.mn/мэдээ/илтгэл/ - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх чиг үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийн гишүүнээр Комиссыг төлөөлж ажилласан. Хуулийн төсөлд хүчирхийлэл үйлдэгч эрчүүдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт, хүчирхийллийн
---	--

		<p>хоширогч нарт үзүүлэх үйлчилгээний төрлийг тодорхой болгох чиглэлээр саналуудыг тусгуулсан. (ХЭҮК, 2015 он) (Ажлын хэсгийн тушаал хавсаргав. Хавсралт 2)</p> <p>- Уг хуулийг олон нийт болон хууль хэрэгжүүлэгч нарт сурталчлан таниулах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн. (Хэвлэлийн бага хурал зохион байгуулсан бичлэгийг CD -д хавсаргав.) Жич: Энэ чиглэлээрх хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлагуудын жагсаалтыг 14 дэх хэсгээс үзнэ үү.</p> <p>4. Комисс 2017 онд хүний эрхийн асуудлаар нийт 6 багц сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Монголын Хуульчдын Холбооны чиг үүргийн хороогоор батлуулж, магадлан итгэмжлүүлсэн. Энэ ажлын хүрээнд “жендэр ба хүний эрх” болон “гэр бүлийн хүчирхийлэл ба хүний эрх” сургалтын гарын авлагыг хариуцан боловсруулж, сэдвийн дагуу 2018 оноос “Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүдэд кредит олгох хуульчдын багц цагийн сургалтад сургагч багшаар ажиллаж байна.</p> <p>5. Ажлын байрны бэлгийн дарамтаас, урьдчилан сэргийлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл ажиллагаанд 2009 оноос хойш тогтмол оролцож ирсэн. Энэ хүрээнд ажлын байрны бэлгийн дарамтын асуудлаарх төрийн бус байгууллагуудын эвслийн гишүүнээр ажиллаж, ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдлыг шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх талаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хамтарсан санал боловсруулсан. Энэ ажлын дагуу Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоотой хамтран 2017 оны 6 дугаар сарын 29-нд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, саналаа танилцуулж, хуулийн төсөлд тусгуулсан. Мөн ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, энэ талаарх гомдлыг шийдвэрлэх үр дүнтэй механизмыг бүрдүүлэх, эрх зүйн орчинг бий болгох чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагад удаа дараагийн ярилцлага, мэдээлэл өгч, энэ чиглэлээрх Комиссоос зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлуудыг хариуцан ажиллаж ирсэн. (ХЭҮК, 2017 он) Жич: Энэ чиглэлээрх хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлагуудын жагсаалтыг 13 дахь хэсгээс үзнэ үү.</p> <p>https://www.facebook.com/MUEHolboo/posts/1483529891732028/</p> <p>6. Комиссын даргын тушаалаар батлагдсан Монгол Улсын Их хурлаар хэлэлцэж буй хууль тогтоомж, бодлогын төслүүд хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар бодлогын дүн шинжилгээ, санал боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр 2013 оноос хойш ажиллаж, Согтуурах мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн төсөл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэх зэрэг хуулийн төсөлд санал өгч ажилласан.</p>
--	--	---

		<p>7. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдэд эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажлыг 1997 оноос хойш хийж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын сэтгэл зүйн онцлог, хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудлаар кэйс мэдээлэл цуглуулж сургалт, сурталчилгааны ажилдаа тогтмол ашиглаж ирсэн. (ХЭҮТ, ХЭҮК)</p> <p>8. Монгол Улсад хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бий болгоход хувь нэмэр оруулах үүднээс Комиссын даргын 2016 оны А/3 тушаалаар батлагдсан хүний эрхийг хамгаалагчдын тухай бие даасан хуулийн төслийн боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, 4 бүлэг 14 зүйл бүхий “Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн төслийг боловсруулж, хууль санаачлагч гишүүдэд хүргүүлсэн. Энэ хуулиар “хүний эрхийн хамгаалагч”-ийг анх удаа тодорхойлон, тэдний эрх зүйн байдлыг баталгаажуулж, хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоог бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн билээ. Энэ хүрээнд нийт 10 гаруй удаагийн хурал, уулзалтыг зохион байгуулах, гишүүдийг мэдээллээр хангах, төсөлд санал авах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг ажлыг ажлын хэсгийн гишүүдтэй хамтран гүйцэтгэж ирсэн. Мөн хүрээнд Монгол Улс дахь эмэгтэй хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдлын талаарх” НҮБ-ын тусгай илтгэгчид мэдээлэл хүргүүлсэн. (ХЭҮК, 2016-2019 он)</p> <p>9. Монгол улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл бичих үйл ажиллагаанд 2010 оноос хойш оролцож, жил бүр тодорхой хүний эрхийн асуудлаар судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалт хийж, иргэдийн өргөдөл гомдол, Комиссын гишүүний шаардлага зөвлөмжийн хэрэгжилт, төр, төрийн бус байгууллагын судалгаа мэдээлэлд үндэслэн нийт 10 гаруй илтгэлийг бие даан болон ажлын хэсгийн гишүүдийн хамт боловсруулж байсан. (ХЭҮК, 2010 оноос өнөөг хүртэл) Боловсруулсан илтгэлийн жагсаалтыг 13 дахь хэсгээс үзнэ үү.</p> <p>10. Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулах “хохирогч хамгаалал” төслийн зохицуулагчаар ажиллаж, хүчирхийллийн хохирогч тэр дундаа хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд ээлтэй орчныг бүрдүүлэх олон улсын тэргүүн туршлагыг анхлан Цагдаагийн байгууллагад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Энэ ажлын хүрээнд насанд хүрээгүй хүүхэд, эмэгтэйчүүд, хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчоос ганцаарчилсан байдлаар мэдүүлэг авах хохирогчдод ээлтэй тусгай өрөөг бий болгох, олон дахин мэдүүлэг аль болох авахгүй байх зорилгоор мэдүүлгийг видео хэлбэрээр баримтжуулах, Цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн хохирогчтой харилцах журам батлуулах, хүчирхийллийн хохирогчийн сэтгэл зүйн онцлог, хэрхэн харьцаж мэдүүлэх авах талаарх сургалт зэрэг олон цогц ажлуудыг удирдан зохион байгуулж байсан. Дээр дурдсан мэдүүлэг авах өрөөг НЦГ-ын харьяа Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд нээж байсан бол одоо бүх дүүргийн цагдаагийн хэлтсүүд энэ жишгээр мэдүүлэг авах тусгай өрөөтэй болсон байна. (ХЭҮТ, 2006 он)</p>
10	Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах	

	<p>чиглэлээр эрхэлсэн ажил Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. 	<p><u>Хүний эрхийн Үндэсний Комисст</u> Ажилласан нийт жил: 10 жил 10 сар</p> <p>2015-2020 Олон улсын гэрээ эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах референт 2013-2015 Захиргаа Хамтын ажиллагааны хэлтсийн дарга 2011-2013 Сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга 2009-2011 Бодлого, дүн шинжилгээ хариуцсан референтээр тус тус эрх зүйч мэргэжлээр ажилласан.</p> <p><u>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр :</u></p> <ul style="list-style-type: none"> - Хариуцсан эрхийн чиглэлээр хүний эрхийн сургалт, сурталчилгааны ажлыг удирдан зохион байгуулах, үр дүнг үнэлэх; - хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах; - хариуцсан эрхийн чиглэлээр хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх төрөл бүрийн ном, гарын авлага, материалуудыг хэвлэн гаргах, удирдан гүйцэтгэх; - хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх; - хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор хариуцсан эрхийн чиглэлээр онол практикийн бага хурал, семинар, хэлэлцүүлэг, төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах; - Комиссоос бусад байгууллагуудтай байгуулах Харилцан ойлголцол, хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг боловсруулах, батлуулах; - Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж, зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах, тайлан, мэдээлэл боловсруулах, шаардлагатай зохицуулалт хийх;
11	<p>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. 	<p>1. Хүний эрх эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих хүрээнд 2010 оноос хойш Комиссын хяналт шалгалтад оролцож ирсэн. Энэ хүрээнд хорих анги, цэргийн анги, цагдан хорих, баривчлах, эрүүлжүүлэх байр, хүүхдийн асрамж, халамжийн төвүүдэд Комиссын гишүүний удирдлагын дор хяналт шалгалтыг зохион байгуулахад оролцож ирсэн. Тухайлбал 2019 онд орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж буй байдалд хяналт шалгалт хийх ажлын хэсэгт ажиллаж, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгуудын төрийн захиргааны нийт 7 байгууллагад Комиссын гишүүний удирдамж, чиглэлийн дагуу хяналт шалгалт хийж, үр дүнг Комиссын гишүүнд танилцуулж, зөрчлийг арилгуулах талаар гишүүний шаардлага, зөвлөмжийн төслийг боловсруулсан. (ХЭҮК, 2019 он)</p> <p>2. 2009 оноос хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцож төр, төрийн бус байгууллага, олон нийтэд чиглэсэн сургалтуудыг тогтмол зохион байгуулж ирсэн. 2011 онд Комиссын сургалт, сурталчилгааны хэлтсийн даргаар ажиллаж байхдаа хүний эрхийн сургагч багш бэлтгэх ажлыг эхлүүлж байсан бөгөөд одоогийн байдлаар Комисс жендэр ба хүний эрхийн асуудлаар үндэсний хэмжээнд 400 гаруй сургагч багшийг бэлтгэсэн байна.</p> <p>Тухайлбал 2018 онд Комиссоос 21 аймгийн төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн</p>

		<p>асуудал хариуцсан албан хаагчдыг сургагч багшаар бэлтгэх бүсчилсэн сургалтыг зохион байгуулахад оролцож, “жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл” сэдвийг хариуцан заасан. Энэхүү сургалтын үр дүнд зөвхөн сургагч багш бэлтгэхээс гадна төрийн захиргааны албан хаагч өөрийн аймаг, сум, багийн хэмжээнд төрийн захиргаан дахь жендэрийн тэгш байдлын асуудлаар бие даан сургалт явуулах арга зүй, аргачлалтай болсон.</p> <p>Мөн онд хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын хүний эрхийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд ЦЕГ, ШШГЕГ, ЗХЖШ, ХХЕГ байгууллагад жендэр ба хүний эрхийн сургагч багш тус тус бэлтгэсэн. (ХЭҮК, 2018 он)</p> <p>3. НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг, Монгол Улсын Засгийн газрын илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын гэрээний Хороодоос гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд хариуцсан эрхийн чиглэлээр хяналт тавих хүрээнд “Жендэрийн тэгш байдал”, “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог сайжруулах”, “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвийн хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэлд тусгасан. (ХЭҮК, 2018 он). http://nhrcm.gov.mn/мэдээ/илтгэл</p> <p>4. Өсвөр насны охид, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүрийн 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”- г зохион байгуулахад тогтмол оролцож ирсэн. Энэ хүрээнд Жендэрийн үндэсний хороо, Хүчирхийллийн эсрэг Үндэсний Төв гэх мэт төр болон төрийн бус байгууллагуудтай хамтран төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Тухайлбал 2018 онд Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран Налайх дүүргийн иргэдийн дунд зохион байгуулсан “Нарны охид” арга хэмжээнд оролцож, танилцуулж, охидын бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн асуудлаар илтгэл тавьж, хэвлэл мэдээлэлд ярилцлага өгсөн. (ХЭҮК, 2018 он)</p> <p>5. Хариуцсан эрхийн чиглэлээр онол практикийн бага хурал, семинар, хэлэлцүүлэг зэрэг төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал 2018 онд “Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх нь: Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа” онол практикийн бага хурлыг зохион байгуулахад оролцож, Ерөнхий сайдын илгээлт, хурлаас гарсан үр дүнг нэгтгэн гишүүний зөвлөмжийн төслийг боловсруулсан. Энэхүү онол практикийн бага хурлаар жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагууд харилцан мэдээллээ солилцож, ололт амжилт, саад бэрхшээл, хамтрах асуудлаа тодорхойлсон үр дүнтэй арга хэмжээ болсон. (ХЭҮК, 2018 он)</p> <p>6. Төрийн албан хаагчийн хүний эрхийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх хүрээнд төрийн албаны сонгон шалгаруулалтад оруулах тестийг боловсруулах ажилд Комиссыг төлөөлөн оролцож, хүний эрхийн асуудлаар 100 асуулга бүхий сорилын тестийг боловсруулсан. Уг тестүүд 2018 оны “Төрийн Албаны зөвлөлийн төрийн албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтад бэлтгэх гарын авлага” номд хэвлэгдэн гарсан болно. (ХЭҮК,</p>
--	--	---

		<p>2018 он)</p> <p>7. Хариуцсан эрхийн хүрээнд Комиссын “жендэр ба хүний эрх”, “гэр бүлийн хүчирхийлэл ба хүний эрх”, “ажлын байрны бэлгийн дарамт, “ жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл”сэдэвт сургалтын гарын авлагыг тус тус боловсруулсан. Эдгээрт жендэрийн үндсэн ойлголт, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, жендэрийн тэгш байдлыг хангах талаарх олон улсын баримт бичгүүд тэдгээрийн үзэл баримтлал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд, жендэрийн тэгш байдал зөрчигдсөн тухай гомдол,түүний шийдвэрлэлтийн талаарх агуулгуудыг багтаасан болно. Уг гарын авлагын дагуу Комиссын сургалт явагддаг. (ХЭҮК, 2016 он)</p> <p>8. Комиссын үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Комиссын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн даргаар 2013 оноос ажиллаж ирсэн. Энэ хүрээнд Орон тооны бус зөвлөлийн /ОТБЗ/ улирал тутмын хурлыг зохион байгуулах, гишүүдийг мэдээллээр хангах, Комиссын үйл ажиллагаанд татан оруулах, тэдний санал санаачлагыг дэмжиж хамтарсан үйл ажиллагаануудыг зохион байгуулж ирсэн. Жишээлбэл 2019 онд Комиссын гишүүн, ОТБЗ-ийн дарга П.Оюунчимэгийн удирдлага дор Орон тооны бус зөвлөлийн гишүүд ГБХЗГ-ын харьяа “Нарт хангай төв”- ийн хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай танилцаж, хүүхэд оргох шалтгаан нөхцөл, хүүхдийг дарамталдаг зэрэг зөрчлүүдийг илрүүлсэн. Энэ талаар ГБХЗГ–т танилцуулж, Комиссын гишүүний шаардлагаар тус төвийн үйл ажиллагааг хаалгуулсан.</p> <p>9. Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр төрөл бүрийн судалгааны ажлуудад оролцож ирсэн. Үүнд: 2018 онд “Өсвөр насны охидын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн асуудал судалгаа”, 2017 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал судалгаа”, 2014 онд “Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тэгш байдлын зарим асуудал судалгаа”, 2013 онд “Бэлгийн цөөнх, ЛГБТ хүмүүсийн эрхийн хэрэгжилт”, 2004 онд “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээ шаардлага” зэрэг судалгаанд оролцож ирсэн. Эдгээрээс хамгийн томоохон судалгаа нь 2005 онд хийсэн Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн хамгаалал, хохирогчийн аюулгүй байдал, хохирол барагдуулах асуудлыг Монголд анх удаа хөндөн гаргасан “Гэмт хэргийн хохирогч хамгаалал” судалгаа болно. Уг судалгааны үр дүнг Хууль зүй Дотоод хэргийн яам, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн хамтран зохион байгуулсан “Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн хамгаалалтын өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох арга зам” бага хуралд танилцуулсан. (ХЭҮТ,2005 он)</p> <p>10. Уул уурхай ба хүний эрх олон улсын бага хурлыг Монголд анх удаа зохион байгуулахад оролцож, уул уурхайгаас үүдэлтэй хүний эрхийн асуудлаарх судалгааг эмхтгэн “Баримтын хуудас”-ыг боловсруулан гаргасан нь уул уурхайгаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлүүдийг баримтад тулгуурлан олон нийт, шийдвэр гаргагчдад ойлгуулахад чухал эх сурвалж болсон. (ХЭҮК, 2010 он)</p>
--	--	--

12	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар</p> <p>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл <p>Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.</p>	
13	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.</p>	
14	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон</p>	<p>Өөрийн боловсруулсан нийтлэл:</p> <p>1. “Хүний эрхийн хамгаалагчдад хамгаалал хэрэгтэй юу?” нийтлэл, “Хүний эрх онол арга, зүйн сэтгүүл” 2010/3 дугаарт, ХЭҮК http://nhrcm.gov.mn/мэдээ/хүний-эрх-сэтгүүлийн-бүх-дугаар/</p> <p>2. “ХЭҮК ба иргэний нийгмийн хамтын ажиллагаа” Хүний эрх онол арга, зүйн сэтгүүл 2012 /1/ дугаарт, ХЭҮК http://nhrcm.gov.mn/мэдээ/хүний-эрх-сэтгүүлийн-бүх-дугаар/</p>

<p>аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.</p> <p>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.</p>	<p>3.“Монгол Улс ба нэмэлт протокол- үгийг үйл хэрэг болгоход тулгарах бэрхшээл”нийтлэл. Эми Рожерсийн хамт нийтлэн Opcedaw.wordpress.com-д хэвлүүлэв.2013.07.04 https://opcedaw.wordpress.com/, ХЭҮК</p> <p>Байгууллагын нэрийн өмнөөс боловсруулж хэвлүүлсэн материал:</p> <p>Илтгэлүүд: http://nhrcm.gov.mn/мэдээ/илтгэл</p> <p>-Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилт (10 жилд) /Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 10 дахь илтгэл ХЭҮК, 2011 он/</p> <p>-Хөдөлмөрлөх, үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх, нийгмийн халамж хамгаалалд хамрагдах зэрэг эдийн засгийн эрх”. /Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 10 дахь илтгэл ХЭҮК, 2011 он</p> <p>-Хөдөлмөрлөх эрхтэй холбоотой зарим асуудал /Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дахь илтгэл, ХЭҮК, 2012 он.</p> <p>-“ЛГБТ хүмүүсийн хүний эрхийн нөхцөл байдал”/Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл, (ХЭҮК, 2013 он)</p> <p>- “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл” (ХЭҮК, 2014 он).</p> <p>- Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тэгш байдлын зарим асуудал”,Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. (ХЭҮК, 2014 он)</p> <p>-Төрөлжсөн асрамжийн газар дахь хүний эрхийн асуудалМонгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дахь илтгэл. (ХЭҮК, 2015 он)</p> <p>- “Ахмад настны эрхийн хэрэгжилт”/Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл ,(ХЭҮК, 2016 он).</p> <p>- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. (ХЭҮК, 2017 он)</p> <p>- “НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт” Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дэх илтгэл. (ХЭҮК, 2018 он).</p> <p>-“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний</p>
--	---

		<p>байдлын талаарх 18 дэх илтгэл. (ХЭҮК, 2019 он) гэх зэрэг</p> <p>Ном, гарын авлага :</p> <ol style="list-style-type: none"> 1. “Жендэр ба хүний эрх” сургалтын гарын авлага, Улаанбаатар, Хуудас: 55, ISBN: 978-99973-43-89-5, https://lib4u.net/?lib=nhrc (ХЭҮК, 2016 он) 2. “Хүний эрх эмхэтгэл” номын, “эмэгтэйчүүдийн эрх”, жендэрийн эрх тэгш байдал”, “ажлын байран дахь бэлгийн дарамт” сэдвийг хариуцан боловсруулсан. Мастер принт ХХК , http://nhrcm.gov.mn/мэдээ/хүний-эрх-эмхэтгэл/ (ХЭҮК, 2014 он) 3. “Жендэр ба Хүний эрх” ном, Улаанбаатар, хуудас: 206 ISBN: 978-99978-964-4-5. https://lib4u.net/?lib=nhrc (ХЭҮК, 2018 он) 4. “Уул уурхай ба хүний эрх, баримтат цомог” уул уурхай ба хүний эрх олон улсын бага хуралд зориулан гаргасан. (ХЭҮК, 2010 он) 5. Гэр бүл дэх хүчирхийлэл /Баримтат мэдээлэл/, (ХЭҮТ, 2004 он) http://www.safefuture.mn/book.php 6. Хүчирхийлэл үйлдэж буй эрчүүдийн ухамсар, зан үйлд нөлөөлөх хөтөлбөр /Мэдээллийн цомог, Хүчирхийлэл үйлдэж буй этгээдэд баривчлах шийтгэл оногдуулж байгаа нь үр дүнгүй байгааг харуулсан. / (ХЭҮТ, 2002 он) гэх мэт <p>Илтгэл, лекц:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх” ТББ-ын эвсэл болон МҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан ажлын байрны бэлгийн дарамтыг хориглох асуудлыг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах асуудлаар хийсэн уулзалт хэлэлцүүлэгт АББД ын талаарх Комиссын гомдол шийдвэрлэлтийн асуудлаар илтгэл тавив. (Улаанбаатар, 2017.06.29) https://www.facebook.com/MUEHolboo/posts/1483529891732028/ 2. Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан “Нарны охид” арга хэмжээнд оролцож, өсвөр насны охидын бэлгийн болон нөхөн үржихүй эрхийн талаар илтгэл тавив. (Налайх дүүрэг 2018 он) https://dnn.mn/өсвөр-насны-охидын-хөгжил-хамгаалалд-зориулсан-танхим-нээв/ 3. Эрдэнэт үйлдвэрээс зохион байгуулсан “уурхайчин эмэгтэйчүүд хөгжлийн төлөө” үндэсний чуулганд оролцож “эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилт” сэдэвт салбар хуралдаанд илтгэл тавив. (Эрдэнэт хот, 2018.04.17) http://www.ord.mn/index.php?newsid=14801 4. Хүйсийн тэгш эрхийн төвөөс зохион байгуулсан “Ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэхэд сэтгүүлчдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг ажлын байрны бэлгийн дарамтын асуудлаар Комиссын гомдол шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт илтгэл тавив. (Улаанбаатар хот, 2018.05.11)
--	--	--

		<p>https://www.facebook.com/MUEHolboo/posts/1896101553808191/</p> <p>Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага</p> <ul style="list-style-type: none"> - “Хүний эрхийн хамгаалагчийн асуудлаар” өнөөдөр сонин ярилцлага, /2018.10.09/, /unuudur.mn/x-мөнхзул-сэтгүүлчдийг-шүүх-хүчний-байгууллагаар-дарамтлах-нь-ихэслээ. - “ЛГБТИ хүмүүсийн эрүүл мэндийг зөвхөн ХДХВ, ДОХ-той холбон төсөөлөх нь өрөөсгөл ойлголт” Eagle ТВ нэвтрүүлэг /2018.05.16/. https://lag.mn/news/article204969 - “Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар”, өнөөдөр сонин, /2017.11.30/ https://dnn.mn/x-мөнхзул-эмэгтэйчүүд-сул-дорой-эр-хүний-эрхшээлд-байх-ёстой-гэсэн-хандлага-хүчирхийлэлд-нөлөөлж-байна/ - Ажлын байрны бэлгийн дарамт, Монгол HD телевизийн “Наашаа цаашаа” нэвтрүүлэг 2017.04.21 - “Эмэгтэйчүүдийн эрх” Монгол HD телевиз, 2017.04.21 - “Ажлын байран дахь дарамтын эрх зүйн орчны асуудлаар”, Sonin.mn сайт, 2014.03.31, http://www.sonin.mn/news/gemt-hereg/25314 - ХЭҮК-ын үйл ажиллагаа, “В”ТВ, шууд нэвтрүүлэг, 2011.10.13 - Эмэгтэйчүүдийн эрх” ярилцлага ETV 2012.03.06 - “Сонгох эрх”, МҮОНТВ, 2012.06.06 - “Уул уурхай нүүдэлчдийн соёл” МҮОНТВ, 2012.03.06 - “Уул уурхайн судалгаа”, Монголын мэдээ сонин, 2012.03.06 - “Уул уурхай ба хүний эрх”, нэвтрүүлэг, МҮОНТВ, 2012.05.15, - “Эмэгтэйчүүдийн эрх” Боловсрол ТВ, 2012.11.11 - “Эмэгтэйчүүдийн эрх”, МҮОНТВ, 2012.12.12 - “Гэр бүлийн хүчирхийлэл”, МҮОНР, ярилцлага, 2013.10.16 - “Ялгаварлан гадуурхалт”, Монгол HD, ярилцлага, 2013.08.22 - “Ажлын байрны бэлгийн дарамт”, ETV, 2013.05.27 - “Жендэр ба ажлын байрны бэлгийн дарамт” ТВ-5, 2013.05.08 - “Ажлын байрны бэлгийн дарамт”, МҮОНТВ, 2013.05.17 - “Гэр бүлийн хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин” МҮОНТВ, 2013.04.10 - “Ажлын байран дахь бэлгийн дарамт, хүчингийн гэмт хэрэг” Өглөөний сонин, Өглөө.mn сайт, 2014.04.01, http://www.ugluu.mn/78217.html гэх зэрэг
--	--	---